



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 04 өдөр

Дугаар A/02

Амардалай

2021 оны Цэргийн шинэчилсэн тоо бүртгэл та
явуулах тухай

Монгол улсын Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалт, Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/322 тоот тушаалаар батлагдсан “Цэргийн тоо бүртгэл зохин байгуулах журам”ыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: 2021 оны цөргийн шинэчилсэн тоо бүртгэлийн комиссыг дараахаа бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: С.Нарантунгалаг /ЗДТГ-ын дарга/

Гишүүдэд: П.Мөнхзориг /1-р багийн Засаг дарга/

Г.Сосорбурам /2-р багийн Засаг дарга/

Б.Баатарсүрэн /3-р багийн Засаг дарга/

Б.Баярмаа /ЗДТГ-ын нярав/

Хоёр: Бүртгэлийг 2021 оны 01 дүгээр сарын 04 ны өдрөөс 2021 оны 01 дүгээр сарын 25 ны дотор зохион байгуулж явуулсугай.


Гурав: Улсын хэмжээнд гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, Коронавирус /Ковид-19/-ын тархалтыг хязгаарлах, хавьтлыг бүрэн тогтоох, хянах, улсын хэмжээнд тархахаас сэргийлэх зорилгоор гамшигаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж байгаатай холбогдуулан олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хязгаарласан тул ариутгал, халдвартгүйжүүлэлтийн горимыг чанд сахиж, улсын болон аймгийн Онцгой комиссын шийдвэртэй нягт уялдуулж бэлтгэл ажлыг ханган аль болох олон хүн цуглуулахгүйгээр цэргийн тоо бүртгэлийг зохион байгуулсугай.

Дөрөв: Монгол улсын Дайчилгааны тухай хууль, Батлан хамгаалах тухай хууль, Орон нутгийн хамгаалалтын тухай хууль, Цэргийн албаны тухай хуулиудад заагдсан “Улсын дайчилгааны төлөвлөгөө” болон “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-ны дагуу сумын томилгоот нэгжүүдийн оногдуулан данслагдсан бэлтгэл үүрэгтэй иргэд, авто техник, өөрөө явагч хэрэгсэл, ангийн буу зэргийг нэг бүрчлэн бүртгэж, тоолохыг үүрэг болгосугай.

Тав: Цэргийн бүртгэлийн тайлан, мэдээг 2021 оны 01 дүгээр сарын 29 ны өдөр аймгийн Цэргийн штабт хүргүүлж ажиллахыг ЗДТГ-ын дарга /С.Нарантунгалаг/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

М.БАЯРСҮХ



4880100012